



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сум 13-р цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/150/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

(Хотын нэр оруулах)

2018 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584

Цахим хаяг: [munkhbat@audit.gov.mn](mailto:munkhbat@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424

Цахим хаяг: [tsegsegmaad@audit.gov.mn](mailto:tsegsegmaad@audit.gov.mn)

Аудитор:

Ж.Чогсомжанлав

Утас: 99080969

Цахим хаяг: [Chogsom83@Gmail.com](mailto:Chogsom83@Gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН ХҮҮХДИЙН 13  
ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ц.ОЮУНЧИМЭГ ТАНАА

2019.02.18 № 2/31  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т  
Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2515028

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Ц.Оюунчимэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сум 13-р цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сум 13-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.01-наас 2019.02.12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Гэрээт аудитор Ж.Чогсомжанлав хариуцаж хэрэгжүүлэв. Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн

аудитын газарт 2018 оны 01 сарын 25-ны өдрийн 10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор сумын 13-р цэцэрлэг нь Багш ажилчдын бүтээлч санаачлагыг хөхүүлэн дэмжиж, тэдний ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг ханган, багш ажилтныг багаар ажиллуулан чадваржуулж, сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд цэцэрлэгийн удирдлага, арга зүйч, багш ажилтан нар хамтран СӨБ-ын сургалтын орчны стандартын бүрдүүлэн, хүүхдэд ээлтэй цэцэрлэг болох зорилго тавин ажиллаж байна. ажиллуулан чадваржуулж, сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд цэцэрлэгийн удирдлага, арга зүйч, багш ажилтан нар хамтран СӨБ-ын сургалтын орчны стандартын бүрдүүлэн, хүүхдэд ээлтэй цэцэрлэг болох зорилго тавин ажиллаж байна. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилго тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үзэл баримтлалтай уялдуулан СӨБ –ын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын агуулга, арга зүйд ахиц гарган, хүүхэд нэг бүрийн хөгжлийг хангахад анхаарч ажиллах.
- СӨБ-ын орчны стандартыг мөрдөн хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих боломжийг нэмэгдүүлэх
- Өдөр тутмын үйл ажиллагааг цагийн хуваарийн дагуу үр дүнтэй чанартай, зохион байгуулах.
- Хамт олноороо ёс зүйг эрхэмлэн, ажлын хариуцлагыг эрхэмлэх.
- Хүүхдийн хоол хүнсний хангамж, үйлчилгээ, эрүүл зохистой хэрэглээг хангаж ажиллана.
- Хамран сургалтыг 94 хувьд хүргэж, хувилбарт сургалтыг зохион байгуулах.
- Эцэг эх олон нийттэй хамтран ажиллана.
- Багш ажилчдын ажлын үр дүнг үнэлнэ.

Баянхонгор сум 13-р цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 50 оноо авсан тул мэдээлэл технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянхонгор сумын 13-р цэцэрлэг нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тайлангийн программ "Acoulous", "Цалингийн программ нь "Paywol" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллагбайдлын түвшинг урьдчилсан байдлаар тооцохдоо суурь үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгох нь зохимжтой гэж үзэв.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй болно. Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны Нийт зардал БНА-2019/150/СТА-ТШЗ

243944.7 мянган төгрөг бөгөөд сонгосон суурь үзүүлэлтийг 2 хувиар тооцож, материаллаг байдлын түвшнийг урьдчилсан байдлаар 4,878.89 мянган төгрөгөөр тогтоож, Маягт №Б201-ээр баримтжуулан баталгаажуулв.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй, заруулга хийгдээгүй болно.

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ** Байхгүй

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 223096.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 223073,2 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Амаржаргал гүйцэтгэж, аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн БНА-2019/150/СТА-ТШЗ

гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

#### 3.1 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>27067715.00</u></b>	<b><u>32707584.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	27067715.00	32707584.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	19689200.00	24802669.00
35110	Тусгай зориулалттай материал	19648900.00	24762369.00
35130	Эм боох материал	40300.00	40300.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7378515.00	7904915.00
35410	Бичиг хэргийн материал	282350.00	340800.00
35420	Аж ахуйн материал	130000.00	203100.00
35450	Барилгын засварын материал	77000.00	77000.00
35460	Хүнсний материал	348165.00	743015.00
35470	Бусад хангамжийн материал	6541000.00	6541000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>465259566.60</u></b>	<b><u>483750312.36</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	465259566.60	483750312.36
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	464614233.32	458280979.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	435071372.00	449059172.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	19502973.80	31504758.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29906844.27	29906844.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	7433384.01	13657037.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32519860.62	32997360.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	6354060.34	9606046.90
39217	Ном	406574.58	1085444.58
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	645333.28	25469333.24
39301	Програм хангамж	880000.00	880000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	234666.72	410666.76
39303	Бусад биет бус хөрөнгө		25000000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>492327281.60</u></b>	<b><u>516457896.36</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>492327281.60</u></b>	<b><u>516457896.36</u></b>

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	492327281.60	516457896.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	0.00	25000000.00
51101	Өмч: - төрийн		25000000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	492327281.60	491457896.36
51210	Өмнөх үеийн үр дүн	492327281.60	492327281.60
51220	Тайлант үеийн үр дүн		-869385.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>492327281.60</u></b>	<b><u>516457896.36</u></b>

СТ-2А

**3.2. САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>221375306.00</b>	<b>243075312.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2752030.00</b>	<b>13987800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2752030.00	13987800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2618030.00	13987800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20030.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2598000.00	13987800.00
120009	Бусад орлого	134000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>218623276.00</b>	<b>229087512.70</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	217465600.00	223096300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	217465600.00	223096300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1157676.00	4231534.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1157676.00	4231534.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>233851000.00</b>	<b>243944697.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>233851000.00</b>	<b>243944697.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	222569527.00	239292205.94
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	129800100.00	133833000.00
210101	Үндсэн цалин	118612661.00	120513500.00
210102	Нэмэгдэл	5045500.00	5045800.00
210104	Урамшуулал	6141939.00	8273700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14263300.00	16060000.00
210201	Тэтгэврийн даатгал	14263300.00	16060000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20218403.00	22131742.00
210301	Гэрэл, цахилгаан	2672117.00	3768266.00
210302	Түлш, халаалт	15916286.00	15441572.00
210303	Цэвэр, бохир ус	1630000.00	2921904.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2438391.00	2962811.00
210401	Бичиг хэрэг	1189330.00	1255950.00
210402	Тээвэр, шатахуун	170000.00	127500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	448500.00	947461.00
210404	Ном, хэвлэл	18000.00	18000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	612561.00	613900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	32416281.00	38634250.00
210502	Хоол, хүнс	32416281.00	38493650.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1150750.00	1115100.00
210604	Урсгал засвар	1150750.00	1115100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	63000.00	68700.00
210702	Дотоод албан томилолт	63000.00	68700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	446100.00	2381678.70

**Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	446100.00	2381678.70
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21773202.00</b>	<b>22104924.24</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	747150.00	451500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	65100.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20960952.00	21653424.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11281473.00</b>	<b>4652492.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>11211776.00</b>	<b>4629434.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1157676.00	4231534.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4267400.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5786700.00	397900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>69697.00</b>	<b>23058.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69697.00	23058.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-12475694.00</u></b>	<b><u>-869385.24</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-12475694.00</u></b>	<b><u>-869385.24</u></b>

СТ-2А

**3.3. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>218777306.00</b>	<b>229087512.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>154030.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	154030.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20030.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20030.00	
120009	Бусад орлого	134000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>218623276.00</b>	<b>229087512.70</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	217465600.00	223096300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	217465600.00	223096300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	1759678.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1759678.70
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1157676.00	4231534.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1157676.00	4231534.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>218777306.00</b>	<b>229087512.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>218777306.00</b>	<b>229087512.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>207495833.00</b>	<b>224435020.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	129800100.00	133833000.00
210101	Үндсэн цалин	114826400.00	120513800.00
210102	Нэмэгдэл	5045500.00	5045500.00
210104	Урамшуулал	9928200.00	8273700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14263300.00	16060000.00
210201	Тэтгэврийн даатгал	14263300.00	16060000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20218403.00	22089242.00
210301	Гэрэл, цахилгаан	2672117.00	3768266.00
210302	Түлш, халаалт	15916286.00	15399072.00
210303	Цэвэр, бохир ус	1630000.00	2921904.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2608430.00	3567600.00
210401	Бичиг хэрэг	208230.00	88400.00
210402	Тээвэр, шатахуун	170000.00	170000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	448500.00	947461.00

**Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210404	Ном, хэвлэл	43300.00	48900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1738400.00	2312839.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31824500.00</b>	<b>41348100.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40300.00	45700.00
210502	Хоол, хүнс	31784200.00	38888500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2413900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4636700.00</b>	<b>1150100.00</b>
210604	Урсгал засвар	4636700.00	1150100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>63000.00</b>	<b>68700.00</b>
210702	Дотоод албан томилолт	63000.00	68700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>446100.00</b>	<b>2381678.70</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	446100.00	2381678.70
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3635300.00</b>	<b>3936600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3481800.00	3783100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	153500.00	153500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11281473.00</b>	<b>4652492.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>11211776.00</b>	<b>4629434.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1157676.00	4231534.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4267400.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5786700.00	397900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>69697.00</b>	<b>23058.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69697.00	23058.00

СТ-4А

**3.4. ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>					0.00
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>492,327,281.60</b>	<b>0.00</b>	492,327,281.60
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			492,327,281.60		492,327,281.60
D08	Тайлант үеийн үр дүн	25,000,000.00		-869,385.24		24,130,614.76
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>25,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>491,457,896.36</b>	<b>0.00</b>	516,457,896.36

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	320286400.00	320146806.00	223096300.00	223073242.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	320286400.00	320146806.00	223096300.00	223073242.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	310184900.00	310045306.00	222698400.00	222675342.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	232439300.00	232369603.00	133833000.00	133833000.00
210101	Үндсэн цалин	217465600.00	217395903.00	120513800.00	120513800.00
210102	Нэмэгдэл	5045500.00	5045500.00	5045500.00	5045500.00
210104	Урамшуулал	9928200.00	9928200.00	8273700.00	8273700.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14263300.00	14263300.00	16060000.00	16060000.00
210201	Тэтгэврийн даатгал	14263300.00	14263300.00	16060000.00	16060000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20270000.00	20218403.00	22089300.00	22089242.00
210301	Гэрэл, цахилгаан	2700000.00	2672117.00	3000000.00	3768266.00
210302	Түлш, халаалт	15940000.00	15916286.00	16140000.00	15399072.00
210303	Цэвэр, бохир ус	1630000.00	1630000.00	2949300.00	2921904.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2588400.00	2588400.00	3567600.00	3567600.00
210401	Бичиг хэрэг	188200.00	188200.00	88400.00	88400.00
210402	Тээвэр, шатахуун	170000.00	170000.00	170000.00	170000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	448500.00	448500.00	1160800.00	947461.00
210404	Ном, хэвлэл	43300.00	43300.00	48900.00	48900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1738400.00	1738400.00	2099500.00	2312839.00
2105	<b>Нормативт зардал</b>	31824700.00	31824500.00	41348100.00	41348100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40300.00	40300.00	45700.00	45700.00
210502	Хоол, хүнс	31784400.00	31784200.00	38888500.00	38888500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			2413900.00	2413900.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4636700.00	4636700.00	1150100.00	1150100.00
210604	Урсгал засвар	4636700.00	4636700.00	1150100.00	1150100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	81100.00	63000.00	91700.00	68700.00
210702	Дотоод албан томилолт	81100.00	63000.00	91700.00	68700.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	446100.00	446100.00	622000.00	622000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	446100.00	446100.00	622000.00	622000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3635300.00	3635300.00	3936600.00	3936600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3481800.00	3481800.00	3783100.00	3783100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	153500.00	153500.00	153500.00	153500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10101500.00	10101500.00	397900.00	397900.00
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	0.00	0.00	0.00	0.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10101500.00	10101500.00	397900.00	397900.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	47400.00	47400.00		

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4267400.00	4267400.00		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5786700.00	5786700.00	397900.00	397900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	217465600.00	217395903.00	223096300.00	223073242.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	217465600.00	217395903.00	223096300.00	223073242.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	217465600.00	217395903.00	223096300.00	223073242.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	19.00	19.00	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	5.00	5.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	135.00	135.00	149.00	149.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	135.00	135.00	149.00	149.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	135.00	135.00	149.00	149.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>19.0</b>	<b>19.0</b>	<b>19.0</b>	<b>19.0</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	9.00	9.00	9.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	10.00	10.00

